

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН 19-Р ХУРАЛДААН ХУРАЛДЛАА.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурал 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж “Жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөр”, “Бид оролцъё, хамтдаа хөгжъё” дэд хөтөлбөр, “Говийн гайхамшигт-6” хөтөлбөр, “Аймгийн соёл урлагийн салбарыг дэмжих” зэрэг хөтөлбөрүүдийг тус тус хэлэлцэж, аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн барихаар шийдвэрлэв.

Мөн Чандмань сумд баг нэмж байгуулах тухай хүсэлтийг хэлэлцэж, сумын төвийн багийг бүх сумдад байгуулахыг судлах үүргийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргад үүрэг болголоо.

Сумдад хүйтэн хэлхээний төхөөрөмж нийлүүлэх асуудлыг хэлэлцэж санхүүжилтийг төсөл хөтөлбөрийн зардлаас, мал эмнэлгийн зөөврийн хашааг улсын төсвийн зардлаас гаргаж, бэлчээрийн худгуудын гүйцэтгэлийн тухай тайланг сонсож улсын төсвөөс санхүүжүүлэхээр тус тус шийдвэрлэлээ.

Хөрөнгө акталж данснаас хасах, хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэж аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн барихаар шийдвэрлэв.

“Нийтлэг үйлчилгээ” ОНТҮГ-ын 2018 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг сонсож цаашид үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллахаар шийдвэрлэлээ.

Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын төслийг хэлэлцэж тус журмыг дахин боловсруулж, сайжруулахыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргад үүрэг болголоо.

Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох журмын төслийг хэлэлцэж баталлаа.

Барилга, байгууламж, авто замын ажлыг технологийн зогсолт хийлгэх тухай асуудлыг хэлэлцэж, 2 хэсэгт ажлын хэсэг ажиллан гүйцэтгэлийн хяналт хийж аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл дахин хэлэлцэхээр шийдвэрлэлээ.

Аймгийн төвийн хойд чиглэл болон Дэлгэр сумд шинээр баригдсан цагдаагийн постын цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх талаар хэлэлцэж холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс гаргахаар шийдвэрлэлээ.

Мөн аймгийн төвийн 7 цэгийн 21 камерын цахилгааны эх үүсвэрийн асуудлыг орон нутгийн төсвийн зардлаар санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ.

Мэдээ бэлтгэсэн:
Ц.МӨНХЗАЯА